

1. АМРЫГ АЙЛТГАЖ, МЭНДИЙГ МЭДЭХ ЁС

Алтан намар



Намрын улиралд хэрхэн мэндлэх вэ?

- Сайн байна уу, та?
- Та тарган сайхан намаржиж байна уу?
- Та тавтай сайхан намаржиж байна уу?



Эрдэнэ аавтайгаа хамт хөдөө өвөөгийнхөө очжээ. Аав нь “Сайхан намаржиж байна уу? Мал сүрэг тарган уу?” хэмээн мэндэллээ. Өвөө нь “Сайхан намаржиж байна. Та бүхэн сайхан намаржиж байна уу? Энэ жил сайхан намар болж, мал сүрэг тарга тэвээрэг сайн авлаа” гэж хариулав.

Эрдэнэ “Аав аа, та ирэх бүрдээ өөр өөрөөр мэндлэх юм аа” гэв. Аав нь инээн “Монголчууд жилийн дөрвөн улиралдаа тохируулан мэнд мэддэг ёстой. Тиймээс аав нь намрын улиралд тохирох мэндийг асуусан юм” хэмээлээ.

Тэгвэл өвөл, хавар, зун яаж мэндэлдэг юм бэ? гэж Эрдэнэ ааваасаа сониучирхан асуув.

Өвөл бол “Тарган тавтай өвөлжиж байна уу?, эсвэл “Өвөлдөө өнтэй сайхан орж байна уу?” хэмээн мэндэлдэг. Хавар мал төллөдөг учраас “Сайхан хаваржиж байна уу? Төл мэнд, сүрэг өсөж байна уу?” гэнэ. Харин зун айлчлан ирвэл өвөөтэйгөө “Бие амар, мал сүрэг мэнд, тарган сайхан зусаж байна уу?” гэж мэндлээрэй хэмээгээд хүүгийнхээ толгойг илэв.



Монголчууд улирал тус бүрд хэрхэн мэндэлдэг вэ? Дээрх эхээс мэндийн тохирох өгүүлбэрийг олж бичээрэй.



.....



.....



.....



.....



Ямар улиралд ингэж асуудаг вэ? Яагаад тэгж асуудаг талаар ярилцаарай.

Мал тарга тэвээрэг авч
байна уу?



Мал сүрэг тарга сайн
авав уу?



Төл мэнд, сүрэг өсөж
байна уу?



Сүрэг мэнд, өнтэй
сайхан уу?



- Жижиг цаасан дээр дөрвөн улирлыг тус тусад нь зураарай.
- Улирлын зургаа ээлж дараалан сугалж, тухайн улиралд тохирох үгээр найзтайгаа мэндэлж, хариу мэнд мэдэж тоглоорой.



Улирал бүрд болдог үйл явдлуудад тохируулан мэндийн үгс зохиогоорой.

Намаржаандаа буудаг.	Айргаа исгэж, өвөлдөө нөөцлөн бэлтгэдэг.
Хадлан, бордоогоо авдаг.	Шинэ гэр барьдаг.
Ургацаа хураадаг.	Мал сүрэг нь тарга хүчээ сайн авч гүйцдэг.
Өвөлжөөнийхөө хашаа хороог засаж сэлбэдэг.	Өвөлдөө бэлтгэн эсгийгээ хийж, гэрийнхээ бүрээсийг оёдог.
Унагаа тамгалдаг.	Сургууль цэцэрлэгүүд үүдээ нээж, сурагч багачууд хичээлдээ явна.

2. ЭРДЭНЭТ ХҮН



Багштайгаа ээлжилж уншаарай.

Хүн байхын сайхныг ухаарсан нь

Гэрээ цэвэрлэх дургүй ч гэдсээ дүүргэх дуртай, оройтож босох дуртай ч ороо хураах дургүй, оймсоо ч угаадаггүй нэгэн жаал хүү байжээ. Өнөөх хүү нэг удаа нохойгоо хараад ихэд атаархав. Хэрэв би нохой байсан бол амар байхгүй юу. Хог шүүрдэж, аяга угаахгүй. Эзнийхээ өгсөн хоолыг идчихээд л өдөржин хэвтэнэ гэж боджээ. Тэгтэл бодлыг нь мэдсэн юм шиг гэнэт нэгэн шидтэн гарч ирээд түүнийг хүслээ хэлнэ үү хэмээн эелдгээр асуулаа. Хүү бодох зүйлгүйгээр: - Би нохой болмоор байна гэв. Шидтэн ч түүнийг хоточ нохой болгож орхив. Өвлийн хүйтэнд гадаа хонож, өлөн саарал чоно дайрахад хонь малаа хамгаалав. Өлсөж, бас даарч, нэг шөнийг нүд цавчилгүй арайхийн өнгөрөөлөө. Тэгээд хүү шидтэнээс: - Би нохой байхаа больё. Намайг тасалгааны цэцэг болгоод өгөөч гэж гуйлаа. Хүү хүссэн ёсоороо цэцэг болчихоод зөвхөн ус уугаад, ямар ч хөдөлгөөнгүй өдрийг өнгөрөөв. Цэцэг байх нь тийм ч амар биш байлаа. Жижиг хорхойнууд бие дээгүүр нь гүйлдэж тэсэхийн аргагүй гижиг хүргэнэ. Бас хурц нар шарж, гэрийн хүмүүс услахаа мартаж, ангаж цангана. Тоос шороонд дарагдан тогтсон нэг газар зогсоно гэдэг жаргал биш болохыг мэдэв. Ингээд шидтэнээс: - Намайг буцаагаад хүн болгож өгөөч. Хүн байх нь л хамгийн сайхан юм байна хэмээн өрөвдөлтэйгөөр гуйлаа. Шидтэн хүүг буцаан хүн болгов. Хүү бөөн баяр болж, тэр өдрөөс хойш хойргошин залхуурахыг хол хаяж, ажилсаг авхаалжтай хүү болж, эрдэм номд шамдаж ээж, аавыгаа баярлуулах болжээ.








Зургийг зөв дараалалд оруулаарай.





Чиний бодлоор ямар амьтан байсан нь илүү дээр вэ? Яагаад? Амьтан бүрийн сул болон давуу талыг харьцуулан ярилцаарай.



Өөрийн бодлыг бичье.

Асуулт	Чиний бодлоор	Хүн юугаараа илүү вэ?
Хамгийн хурдан амьтан юу вэ?		Хүн машин бүтээж, үчимбэрээс хурдан давхиж чадна.
Хамгийн хүчтэй амьтан юу вэ?		
Хамгийн өндөр амьтан юу вэ?		

Хүн амьтнаас олон чадвараар дутуу. Гэхдээ хүн ухаантай, бүтээх чадвартай учир хүссэн бүхнээ хийж чадна. Иймд хүн болж төрсөн бид азтай.

3. ХҮНИЙ ТУХАЙ БЯЦХАН ТҮҮХ



Хүн ямар амьтантай хамгийн төстэй бэ?



Бичний гар



Хүний гар

Амьтдын дотроос хүн дүрст бич нь хүнтэй хамгийн төстэй. Бич нь хүний өвөг дээдэс мөн эсэх нь одоог хүртэл маргаантай. Гэвч хүний өвөг дээдэс олон талаар бичнээс илүү байв. Жишээ нь, Бич дөрвөн хөл дэрээ явдаг бол хүн хоёр хөл дээрээ босоогоороо явдаг. Эрхий хуруу нь бусад хурууныхаа өндөгтэй чөлөөтэй нийлдэг учраас, ямарваа зүйлийг сайтар барьж чаддаг, бас илүү том тархитай байжээ. Тиймээс хүн ухаантай бөгөөд бүтээх чадвартай юм.

Эрт дээр үед одоогийнх шиг байшин барилга, машин техник, багаж хэрэгсэл байсангүй. Тиймээс хүмүүс салхи, цас борооноос хоргодох, махчин амьтдаас өөрсдийгөө хамгаалахын тулд агуйд олуулаа амьдардаг байжээ. Чулуугаар зэвсэг бүтээж, гал гаргаж, хоорондоо ярилцаж сурсан нь хүний хамгийн анхны амжилт байлаа. Улмаар хэл яриа хөгжихийн хэрээр хүний сэтгэн бодох, илүү өндөр түвшинд ойлголцох, мэдлэгийг уламжлуулах чадвар нэмэгдэж, хүмүүс тасралтгүй суралцан хөгжиж, хамтран нэгдэж, хийж бүтээсээр өнөөдрийн бидэнд байгаа бүхнийг бүтээж чаджээ.

Тиймээс хүн бол хэл ярианы хөгжил, түүнээс улбаалсан сэтгэн бодох, бүтээн босгох, ухамсраа өндөр түвшинд хөгжүүлэх чадвартай. Мөн сайн, мууг ялган таньж сэтгэлээ жолоодох, бусдыг энэрэн нигүүлсэх, агуу их зорилгыг бий болгож амьдрах зэрэг олон чадвараар амьтнаас ялгаатай, хол давуу билээ.



Хүн яагаад бодож, бүтээж чаддаг вэ? Үүний хариултыг эхээс олж, өнгөөр тодруулан будаарай.



Биеийн туршилт: Бидний бүтээгч гар

- Эрхий хурууны өндгөө бусад хурууныхаа өндөгтэй ээлжлэн нийлүүлж үзээрэй. Долоовор, дунд, ядам, чигчий хурууны чинь өндөг эрхий хуруутайгаа нийлж байна уу?
- Улам хурднаар нэгээс дөрөв тоолж, хуруунуудаа нэг нэгээр нь эрхий хуруутайгаа гурван удаа нийлүүлээрэй.



Бодлын туршилт:

- Эрдэмтэн болсон амьтад байдаг уу?
- Эцэг, эхийнхээ ачийг хариулахыг зорьж явдаг амьтад байдаг уу?
- Амьтад сэтгэлээ жолоодож чадах уу?

4. НАДАД УХААН БИЙ




Чи юу хийж, бүтээхийг хүсдэг вэ?



БИ

Хамгийн хэцүү бодлогын
Хариуг хэн гаргах вэ гэвэл
Би гаргана, надад **ухаан** бий.
Гал түймэрт өртсөн нөхрөө
Гаргаж хэн аврах вэ гэвэл
Би аварна, надад **зориг** бий
Хэн нэгэн маань аюулд ороод
Хэрэгцээ болж цусаа өгөх бол
Би өгнө, надад **сэтгэл** бий
Сахилгагүй хүүхдийг даах
Санал авч, хэн нэгэнд даалгах бол
Би даана, надад **хайр** бий
Эх орноо хамгаалах
Эр цэргийн албанд би явна
Надад **эх орон** бий

С.Надмид



Шүлэгт юу, юуг хийж чадна гэсэн байна вэ?

Найзыгаа галаас аварч чадна	Эх орноо хамгаална	Аюулд орсон нөхөртөө цусаа өгнө
Ээж аавынхаа ачийг хариулна	Нэгнийгээ дааж авч тусална	Ном уншина
Хэцүү бодлогын хариуг гаргана	Амьтныг асарч хамгаална	Ажил хийнэ



Бид дараах зүйлсийг яагаад хийж чаддаг вэ?

Хэцүү бодлогыг бодож чадна. Яагаад гэвэл, надад бий.
Гал түймэрт өртсөн нөхрөө аварч чадна. Яагаад гэвэл, надад бий.
Хэн нэгнийг даан авч тусалж чадна. Яагаад гэвэл, надад бий.



Чи юу юу хийж чадах вэ?



“Би том болоод...” сэдвээр өөрийн бодлыг бичээрэй.

5. ХҮНИЙ ХОВОР ЗАЯА



- Шоргоолжны нэг үүрэнд долоон тэрбум (7 000 000 000) шоргоолж байдаг гэвэл чи итгэх үү? Тэгвэл ойгоор зугаалж явахад хэчнээн олон шоргоолжны үүр харагддаг билээ?
- Энэ үүрэнд хэр олон шоргоолж байна гэж чи бодож байна вэ?
- Тоолж баршгүй олон өөр ямар амьтан байдаг вэ?



Зээ охины асуулт

Номин охин долоон настай. Нэгэн удаа дүүтэйгээ нохой болон тоглоод, газарт дөрвөн хөллөөд хуцаж гарчээ. Гэтэл эмээ нь:

- Цөг гэм, хүн байж амьтан болоод муу ёртой юм гэж унтууцжээ. Тэгэхэд нь Номин:

- Тэгвэл би яагаад хүн болж төрсөн юм бэ гэж асуув. Эмээ нь:

- Ай, хүн болж төрөх чинь маш их хувь заяа шүү дээ. Зүйрлэвэл нэг зүүг дээш харуулж тогтоогоод, түүн рүү атга шар будаа цацвал нэг нь ч зүүний үзүүр дээр тогтохгүй. Шар будаагаа дахин дахин уйгагүй цацаад байвал хэзээ нэгэн цагт зүүний үзүүрт нэг будаа тогтох тохиолдол гарах биз. Хүн болж төрнө гэдэг үүнтэй адил маш ховор тохиолдол юм шүү дээ гэжээ.



Асуултын дагуу ярилцаарай.

- Хүн болж төрөхийг Номин охины эмээ юутай зүйрлэсэн бэ?
- Бид хүн биш, амьтан болон төрж болох байсан болов уу?



Дараах зүйр үгсээс хоёрыг сонгон, утгыг тайлбарлаж бичээрэй.

- Биеэ мэдвэл хүн, бэлчээрээ мэдвэл мал
- Хүн хэлээрээ, мал хөлөөрөө.
- Хүний хүчинд хүн болдог, усны хүчинд загас болдог.
- Хүний сайн нь үнэнч, хүлгийн сайн нь жороо.
- Хүн өөдөө, ус уруугаа
- Хүний эрээн дотроо, могойн эрээн гаднаа.
- Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа.
- Хүнд сэтгэл байдаг, цахиурт гал байдаг.
- Хүний хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ.
- Хүн нэрээ, тогос өдөө.

Хүн болж төрсний учир эрдэм номд шамдан хичээж, бусдыг энэрэн хайрлаж, их үйлсийг бүтээх ёстойг ухаараарай.